

**ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**2018 ОНЫ “ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХИ ТАНИЛЦУУЛГА**

Тус газар нь 2018 онд “Шилэн дансны тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.2¹ хэсэг, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.2.3.5², Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.2³-д заасны дагуу хуулийн хэрэгжилт болон мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, цаг тухайд нь байршуулсан эсэхэд хяналт тавьж, улирал бүр үнэлгээ өгч, зөвлөмж хүргүүлэн эрсдэлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Тус газраас энэхүү чиг үүргийнхээ хүрээнд Сангийн сайд, дотоод аудитын хорооны даргын “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай” 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 13/05 дугаар тогтоолоор өгсөн зөвлөмж, Үндэсний аудитын газар /УАГ/-ын Гадаад харилцааны сайд /ГХС/-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд “Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн байрлуулах, уг хуулийг мөрдөж ажиллах” талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаа. Тухайлбал:

1. ТНБД-ын 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн “Санхүү, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах, төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх тухай” 13/1371 дүгээр зааварлах захидлыг нийт Дипломат төлөөлөгчийн газар /ДТГ/-уудад хүргүүлсэн.

2. “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийн талаар танилцуулах хуудас 3, мэдээллийн цахим хуудсанд байршуулах зөвлөмж, мэдээллээ бүрэн байршуулах, нөхөж байршуулах тухай хугацаатай үүрэг даалгавар бүхий /Е/13/18/98, Е/13/18/308, Е/13/18/353, Е/13/18/411, Е/13/19/16/ нийт 5 цахим шууданг ДТГ-уудад хүргүүлэв.

¹ Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

² шилэн дансны хөтлөлт;

³ Дотоод аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ

3. ҮАГ-аас 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 01/1950 тоот албан бичгээр 2017 оны 4 дүгээр улирлаас 2018 оны 3 дугаар улирлын “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийх албан бичиг ирүүлсний дагуу нийт төсвийн ерөнхийлөн захирагчаас хэрэгжүүлж буй дотоод хяналтын мэдээллийг 47 байгууллагаас гаргуулан авч нэгтгэн 2018 оны 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлсэн болно.

4. “Шилэн дансны тухай хууль”-ийн улирал бүрийн хэрэгжилтийн талаар яамны удирдлагад танилцуулан Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/-аас өгсөн чиглэлийн дагуу “Шилэн дансны тухай хууль”-ийн 2018 оны 2, 3 дугаар улирлын хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, “С”, “D” үнэлгээ авсан ДТГ-уудад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар зааварчлагаа, чиглэл бүхий нийт 29 цахим шууданг хүргүүлэн ажиллав.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу мэдээллийг байршуулсан байдлыг 2018 оны жилийн байдлаар дүгнэхэд Төсвийн ерөнхийлөн захирагчийн 47 байгууллагын дүнгээр “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт **98.49** хувийн гүйцэтгэлтэй, нийт төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа 3 байгууллага, 42 ДТГ, ТӨБ 1, төслийн 1 байгууллага цахим тайланг хуулийн хугацаанд илгээсэн болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг өмнөх онтой харьцуулан авч үзвэл хэрэгжилт 10.72 хувиар өссөн байна



Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдлыг хуулийн хугацааны байдлаар өмнөх онтой харьцуулан харуулбал:



Тайлангийн хугацаанд нийт 16 төрлийн давхардсан тоогоор 7107 мэдээлэл цахим хуудсанд байршуулахаас 7000 мэдээлэл буюу 98.49 хувь байршуулж, үүнээс хуулийн хугацаанд 5242 буюу 73.7 хувь, хугацаа хоцорч 1758 буюу 24.7 хувь, 107 буюу 1.51 хувь нь мэдээллээ байршуулаагүй байна.




Мэдээлэл байршуулаагүй байгаа байдал нь энэ жилийн тухайд нийт ДТГ-уудад санхүүгийн шинэ программыг нэвтрүүлэн ихэнх газрууд нь жилийн эцсийн санхүүгийн тайлан нь хугацаандаа гараагүйтэй холбоотой төдийгүй ялангуяа ихэнх ДТГ-уудад мэргэжлийн ня-бо ажилладаггүйтэй холбоотой байна.

Мөн нийт газрууд улирал, хагас жил болон жилд оруулах мэдээллийг хугацаанд нь байршуулахгүй хоцроох нийтлэг дутагдал газруудад гарч байна. Тухайлбал, дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг юм.

МУ-ын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолыг баримтлан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг тооцох аргачлалын дагуу үнэлгээ хийхэд хуулийн хугацаанд байршуулсан байдлаар дүгнэхэд “А” үнэлгээтэй 8, “В” үнэлгээтэй 15, “С” үнэлгээтэй 9, “D” үнэлгээтэй 3, уг журмын 6.2.1.3-д заасан **“эрчимжүүлэх шаардлагатай” /60-с доош хувь/ 12 ДТГ байна. Үүнд:**

Астана, Будапешт, Вашингтон, Гавана, Дели, Канбера, Москва, Истанбул, Оттава, Осака, Санфранциско, Хөххот зэрэг ДТГ байна /Хүснэгт 1/.

“Шилэн дансны тухай хууль”-ийн 2018 оны хэрэгжилтийн байдлыг байгууллага тус бүрийн үнэлгээний эрэмбээр харуулбал:



Дүгнэлт:

Гадаад харилцааны салбарын хэмжээний холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд 2018 оны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **98.49** хувийн биелэлттэй гарч өнгөрсөн онтой харьцуулахад шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 10.79 хувиар өссөн байна.

Мөн шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаандаа байршуулсан байдал 22.2 хувиар өсөж, хугацаа хоцорч байршуулсан байдал 15.7 хувиар, мэдээлэл байрлуулаагүй байдал 8.0 хувиар тус тус буурсан байна.

Иймд салбарын хэмжээнд “Шилэн дансны тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт **“Хангалттай”** биелсэн байна.

Санал:

1. 2019 онд шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулж буй байдалд ДТГ-уудын тэргүүн болон эрх бүхий ажилтан хянаж

тавьж, хуулийн хугацаандаа мэдээллээ бүрэн байршуулж, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах;

2. Шилэн дансны мэдээлэл оруулах санхүүгийн эрх бүхий албан тушаалтныг солигдоход төвийн Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү эдийн засгийн хэлтсээс сургалт болон ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг сайн бэлтгэж, зохих түвшинд мэргэшүүлэх;

3. Шилэн дансны цахим хуудасны цэсэнд Сангийн яамны холбогдох газар нэгжээс цахим шуудангаар холбогдох мэдээллийг байнга хүргүүлж байгаа бөгөөд тэрхүү цахим мэдээллээр уг дансыг хэрхэн хөтлөх мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч байгааг ДТГ-уудын тэргүүн болон эрх бүхий ажилтан байнга шалган, хүлээн авч үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах;

4. “Шилэн дансны тухай хууль”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг зөрчсөн, 2018 оны мэдээ тайлангаа цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулаагүй, албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй “F” үнэлгээтэй 12 ДТГ-н тэргүүн, нягтлан бодогч нарт “Төрийн албаны тухай хууль”-ийн 48 дугаар зүйл, “Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм”-ийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн хариуцлага тооцох.

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ